

—
ЖИЛИЙН
ТАЙЛАН


—
20
21
—



Агуулга

Эрхэм зорилго, Хэтийн зорилт.....	04
Бидний үнэт зүйлс.....	06
Байгууллагын танилцуулга.....	06
Гүйцэтгэх удирдлагын мэндчилгээ.....	08
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.....	10
Төлөөлөн удирдах зөвлөл.....	12
Бүтэц, зохион байгуулалт.....	14
Удирдлагын баг.....	16
Хараат бус аудитын тайлан.....	18
Санхүүгийн үзүүлэлтүүд.....	26
2021 оны онцлох үйл явдлууд.....	28
Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг.....	30
Технологийн инноваци.....	32
Хүний нөөцийн үйл ажиллагаа.....	34
Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ.....	36
Эрсдэлийн удирдлага.....	38
Салбар нэгжийн мэдээлэл.....	40
Бидний түншүүд.....	42





ЭРХЭМ ЗОРИЛГО

Ухаан, Хүсэл, Уран сэтгэмж
Улам шинэлэг хамт олноороо
Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөх банк

ХЭТИЙН ЗОРИЛТ

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний цахим болон биет сувгийн оновчтой хослолоор харилцагчиддаа бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэдэг, харилцагчийн гайхалтай үйлчилгээтэй, нийгмийн хариуцлагаараа манлайлагч банк болох

■ Бидний үнэт зүйлс |

ХҮМҮҮС

Сэтгэлтэй, Мэдрэмжтэй, Эрдмүүртэй

Бүх зүйл хүмүүсээс үүдэлтэй. Баг, хамт олон, бизнес, үйлчилгээний байгууллагын аль нь ч сэтгэлтэй, мэдрэмжтэй, эрч хүчтэй хүмүүсгүйгээр оршин тогтнох боломжгүй.

Тиймээс Хүмүүс бусад зүйлсийг бий болгон, нийцүүлэн зангидаж, гол Цөм нь болж байгаа юм. Манай хамт олон төрөл бүрийн мэргэжил, нас, хүйс, ажил амьдралын туршлага, үндэстний төлөөллөөс бүрддэгээр нь бахархаж бид Хүмүүсээ олон төрлийн өнгө, хэмжээ, дүрсээр билэгдлээ.

ҮЙЛ ЯВЦ

Шүүрхэй, Найдвартай, Сааггүй

Хоёр тийш жийн бат зогсох тулгуур хоёр баганын зүүн багана болох Үйл Явц нь бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн судлан бүтээж, эцсийн харилцагчид хэрхэн толилуулж, хүргэхийг хэлж байгаа юм. Харилцагчийн нүдээр харахад зарим зүйлсийг бид явцын дунд хичнээн төвөгтэй болгож хувиргасныгаа тэр болгон ухаардаггүй. Тэгвэл бид Үйл Явцаа ямарваа нэгэн саад төвөггүй, ногоон гэрлээр урсгаж байхыг илэрхийлж Ногоон өнгөөр бүтээлээ.

БҮТЭЭГДЭХҮҮН

Амдуулан бодсон, Амдралаас үүдсэн

Тулгуур хоёр баганын баруун багана болох "Бүтээгдэхүүн" нь бидний үйлчилгээ хүний хэрэгцээг амдуулан бодсон, асуудлыг шийдсэн, бодит амьдралаас үүдсэн байхыг илэрхийлж халуун дулаан, холоос ялгаран танигдах, эрч хүчээр дүүрэн галын Улаан өнгөөр бүтээсэн билээ.

ОРЧИН

Зочломтгой, Тухтай, Халамжтай

Манайхаар орсон хүн зочломтгой, тухтай, халамжтай орчныг мэдрэх учиртайг Хөх Ягаан өнгөөр төлөөлүүлээ. Хөх Ягаан өнгө нь "орчин үе"-ийг илэрхийлдэг өнгө юм.

Байгууллагын танилцуулга



Ариг банк нь (хуучнаар Эрэлбанк) 1997 онд Монгол улсын ууган арилжааны банкуудын нэг болон байгуулагдсан.

2014 онд ребрэндинг хийж байгууллагын нэрээ цэвэр, тунгалаг гэдэг утга агуулгатайгаар “Ариг Банк” хэмээн өөрчилж, шинэ бодлого, шинэ өнгө төрхөөр харилцагч нартаа хүрч үйлчилж эхэллээ.

Бид харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээг тогтвортой хөгжлийн стандартад нийцүүлэн, уян хатан нөхцөлтэйгээр олон төрлийн бизнесийн сувгуудаараа дамжуулан хүргэж байна.

Цаашид Ариг банк нь хэрэглэгчдийн хүсэлд нийцсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэн хүргэж, Финтек буюу санхүүгийн ертөнц дэх технологийн хувьсалд нэгдэн өөрийн үйл ажиллагааны бүтээмж, боломжийг нэмэгдүүлэн, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажиллаж байна.

● БИД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГААР ТЭРГҮҮЛЭГЧ:

- “Утааг хамтдаа устгая” төслийг анх санаачилж Улаанбаатар хотын гэр хороололд ашиглагддаг уламжлалт зуухнаас ялгарч буй хорт утааг технологийн болон санхүүгийн оновчтой шийдэл ашиглан бууруулах, арилгах зорилго дор төр, хувийн хэвшил, олон улсын нийт 9 байгууллагатай хамтран инновацийн төслийг амжилттай хэрэгжүүллээ.

- Бид санаачлан сургуулийн өмнөх боловсролын хүртээмж багатай Налайх дүүргийн 81-р цэцэрлэгт ариун цэврийн өрөө бүхий гэр цэцэрлэгийг Нидерландын ING банк болон НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран бүрэн тохижуулан хүлээлгэн өгч улмаар уламжлал болгон Баянзүрх дүүргийн 172; 251-р цэцэрлэгийн дэргэд хоёр гэр, нэг ариун цэврийн байгууламж бүхий өргөтгөлийг байгуулан

албан ёсоор хүлээлгэн өгсөн.

- Монголд анх удаа ажилтнуудын дүрэмт хувцсаа үндэсний хэв маяг агуулсан, хүний биед хор нөлөөгүй хоёрдогч түүхий эдээр боловсруулсан материалаар хийлээ.



- “Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах журам”-ын дагуу цаас, шил, хуванцар ба ахуйн хог хэмээн 4 ангилж, дахин боловсруулах хогийг “Мог Пластик” ХХК-ийн үйлдвэрт тогтмол нийлүүлэн ажиллаж эхэллээ.

- Монголын Улаан Загалмай Нийгэмлэгтэй хамтран



“Хандивын дэлгүүр” олон улсын туршлагыг Монголд нэвтрүүлж банкны салбаруудад байршуулсан ДЭМ ДЭМЭНДЭЭ хайрцгаар дамжуулан иргэдийн илүүдэл болон хандивлахыг хүсэж байгаа хувцас, эд хогшлыг цуглуулан Монголын Улаан Загалмай Нийгэмлэгт хүлээлгэн өгдөг билээ.



● БИД ТЕХНОЛОГИЙН ИННОВАЦИЙГ АНХЛАН НЭВТРҮҮЛЭГЧ

- Монголд анх удаа гар утсаараа төлбөрийн карт уншигч “SWIPE” төхөөрөмжийг нэвтрүүллээ.
- Монголд анх удаа TCR буюу теллерийн бэлэн мөнгө тоолох, хүлээн авах, хадгалах автомат машиныг нэвтрүүллээ.
- Гар утасны аппликейшн болох ПокетБанкийг зах зээлд гарган улмаар хурууны хээгээр нэвтрэх боломжийг Монголд анх удаа нэвтрүүллээ. Покет Банк аппликэйшнийг ашиглан харилцах болон хадгаламжийн данс нээх боломжтой болсон ба хадгаламж барьцаалсан зээлийг аппликэйшнаар дамжуулан хормын дотор авах боломжийг нэвтрүүллээ.
- Монголд төдийгүй Дэлхийн банкны системд 2 дахь нь болж Хурууны судсаар харилцагчаа таньдаг “iDual” системийг нэвтрүүллээ.
- Дотоодын төгрөгийн картыг чиптэй карт болгон зах зээлд нэвтрүүллээ.
- Ариг Банк нь олон улсын виза /visa/ картаа зайнаас уншуулах дэвшилтэт технологи нэвтрүүлэн, харилцагчдадаа эх орондоо төдийгүй олон улсад төлбөр тооцоогоо илүү хялбараар хийх боломжийг бүрдүүллээ.

● БИД ХАРИЛЦАГЧАА УХААЛГААР ХАЛАМЖЛАГЧ

- Бид Монголын Банк Санхүүгийн салбарт Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015, харилцагчийн үйлчилгээндээ Чанарын менежмент-

Харилцагчийн сэтгэл ханамж ISO 10002:2014 олон улсын стандартуудыг хэрэгжүүлэгч анхны банк болж Австралийн BSC стандартчиллын компаниас Баталгаажуулалтын гэрчилгээг гардан авсан билээ.

- Харилцагчдадаа зориулж онлайнаар буюу arigbank.mn цахим сайтаар дамжуулан брокер диллерийн компаниудад хувьцааны данс болон банкны Эскроу дансыг шинээр нээх боломжийг олголоо.
- Бид харилцагчдад зөвлөх үйлчилгээний Лавлах төвийг 24/7 цагаар ажиллуулж, мөн бусад 17 сувгаар санал хүсэлт хүлээн авч байгаа бөгөөд банкны салбартаа лавлах төвийн утас нь автомат хариулагчгүй, зөвлөх ажилтан шууд утсаа аван зөвлөгөө тусламж үзүүлдэг цорын ганц банк билээ.

● БИДНИЙ ШАГНАЛ

- ASIAMONEY сэтгүүлийн “Нийгмийн Хариуцлагыг хэрэгжүүлэгч Шилдэг Банк” -аар 2017 оноос 2019 онуудад 3 жил дараалан шагнуулсан билээ.



- Монголын Банкны Холбоо (МБХ), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Нидерландын хөгжлийн банк (НХБ) болон Худалдаа, хөгжлийн банкнаас хамтран зохион байгуулж, шийдвэрлэн 2015 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж эхэлсэн Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн хөтөлбөрийн “ТоС Манлайлагч байгууллага”-аар 2017 онд шалгарлаа.
- Тогтвортой санхүүжилтийг түгээн дэлгэрүүлэх олон талт хамтын ажиллагаа сэдвээр хамтран зохион байгуулсан форум нь “Шилдэг ТоС арга хэмжээ” -гээр 2017 онд шалгарлаа.
- Олон улсын CFI.co (Capital Finance Investment) сэтгүүлээс нийгэмд эдийн засгийн үнэ цэнэтэй, чухал хувь нэмэр оруулсан хэмээн Ариг банкыг “Монголын Шилдэг Ногоон Банк” -аар 2018 онд онцолсон.



■ Гүйцэтгэх удирдлагын мэндчилгээ |



**ЭРХЭМ ХҮНДЭТ
ХАРИЛЦАГЧИД, ТҮНШЛЭГЧИД,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БОЛОН
БАНКНЫ АЖИЛТНУДАА,**

Та бүхэндээ 2021 оны ажлын гүйцэтгэлийг танилцуулж байна.

2021 онд Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн ихэнх салбарууд зогсонги байдалд шилжсэн Монголулстөдийгүй дэлхий дахинд томоохон сорилтуудтай нүүр тулсан жилүүдийн үргэлжлэл байлаа. Ариг банкны хувьд 2021 он олон чухал үйл явдлууд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтээр дүүрэн жил байлаа. Тухайлбал: Банкны дунд

болон урт хугацааны бизнесийн шинэ стратегийг батлуулж, банкны бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлж, стратегийн чухал зорилтуудыг хэрэгжүүлэх их ажлын эхлэл тавигдлаа. Банкныхаа дүрмийн санг 64.4 тэрбум төгрөгт хүргэж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг 64.5%-иар хангаж, төлбөр түргэн

гүйцэтгэх чадварыг 103.3%-иар ханган биелүүлснээр бид харилцагч нарынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, банкныхаа нэр хүндийг дахин бататгаж чадлаа. Түүнчлэн чанаргүй зээлийг эргэн төлүүлэх, эрсдэлийн сангийн зардлыг бууруулахад ихээхэн анхаарч ажилласнаар тайлант онд нийт чанаргүй зээлийн хэмжээг өмнөх оноос 22.7 хувиар буурууллаа.

Ариг банкны зүгээс Монгол Улсын Засгийн газар болон Монгол банкны зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн дагуу харилцагчдынхаа зээлийн хугацааг хойшлуулах, зээлийн гэрээний бүтцэд өөрчлөлт оруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлүүдийг сайжруулах, бүх төрлийн зээлийн хүүг үе шаттайгаар бууруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн харилцагчдаа дэмжин ажиллалаа.

Мөн эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөний гол арга хэмжээнүүдийн нэг болох Ажлын байрыг дэмжих 3%-ийн зээлийг харилцагчдадаа олгож, “Шинэ автомашины зээл”, “Хэрэглээний худалдан авалтын зээл” зэрэг зорилтот санхүүгийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж, техник технологийн

хөгжилтэй нийлүүлэн цахим бүтээгдэхүүний шинэ боломжуудыг бий болгосныг дурдахад таатай байна.

2021 онд бидэнтэй хамт байж хамтран ажилласан харилцагчид, түнш байгууллагууд, хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх хуулийн шаардлагыг биелүүлэхэд хичээн зүтгэсэн хувьцаа эзэмшигчид болон цар тахлын хүнд үед үл шантран ажил үүргээ тасалдалгүй гүйцэтгэсэн ажилтан хамт олон та бүхэндээ Ариг банкны удирдлагын багийн өмнөөс талархаж буйгаа илэрхийлж байна.

Ирж буй 2022 онд Монгол улсын “Банкны тухай хууль”-д оруулсан эрх зүйн өөрчлөлт, шинэ заалтуудыг хэрэгжүүлэн, харилцагчдынхаа хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхийн төлөө хичээнгүйлэн ажиллах болно.

Хүндэтгэсэн,

О. Хүрэлбаатар

Гүйцэтгэх захирлын үүрэг
гүйцэтгэгчийг түр орлон гүйцэтгэгч,
Дэд захирал

■ Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл |

57.68%

УЛААНБААТАР ИМПЕКС ХХК

“Ариг Банк” ХХК-ийн толгой компани ба банк, санхүүгийн салбарт хөрөнгө оруулахад төвлөрч ажиллаж байна. Ариг банкны энгийн хувьцааны 57.68 хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 73.18 хувийг иргэн Ш.Баярсайхан, 26.82 хувийг “Номин реалтор” ХХК эзэмшдэг.



ДЭМ САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

“Ариг Банк” ХХК-ийн толгой компани бөгөөд банк, санхүүгийн салбарт голлон төвлөрч ажилладаг. Ариг банкны энгийн хувьцааны 42.32 хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 100%-ийн хувьцааг иргэн Б.Эрдэнэбат эзэмшдэг.

42.32%

Төлөөлөн удирдах зөвлөл



**Пүрэвийн
МӨНХ-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн дарга, хараат
бус гишүүн



**Санжаагийн
САЙНБАТ**

ТУЗ-ийн гишүүн



**Шагдарсүрэнгийн
БАЯРСАЙХАН**

ТУЗ-ийн гишүүн



**Сэнгэдоржийн
ХОСБАЯР**

ТУЗ-ийн гишүүн



**Дэлэгийн
ТҮВШИНТАМИР**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн



**Ганбатын
ТЭМҮҮЖИН**

ТУЗ-ийн дэргэдэх
Дотоод аудитын газрын
захирал

Төлөөлөн удирдах зөвлөл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ариг Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл / ТУЗ/ нь “Банкны тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Ариг Банкны дүрэм” болон “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон журам тогтоомж, дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай биелүүлж ажиллахыг чиглэлээ болгодог.

ТУЗ-ийн үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх, үүрэг зэрэг нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулагдах бөгөөд хуульд заасны дагуу ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн Дарга зарлаж хуралдуулна. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хэрхэн шийдвэрлэсэн тухай тэмдэглэлийг хөтлөн, гарын үсгээр баталгаажуулж хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигч нар болон Монголбанкинд хүргүүлэн ажилладаг. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл зэрэгт холбогдох хороод нь эрх, үүргийн дагуу хяналт тавин ажилладаг болно.

ТУЗ нь банкны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахаар зохион байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх эрхийг банкны Хувьцаа эзэмшигч нар эдэлнэ / Хараат бус гишүүнийг Монголбанкны зөвшөөрснөөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ/

ЭРСДЭЛИЙН УДИРДАГЫН ХОРОО

Банкны зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн, мэдээлэл технологийн болон бусад төрлийн эрсдэлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй бөгөөд журмын хэрэгжилтийг жил болгон хянаж, ТУЗ-д зохистой өөрчлөлт оруулах талаар санал гарган ажиллана.

АУДИТЫН ХОРОО

Банкны санхүүгийн үнэн зөв, бүрэн бүтэн тайлагнал, банканд хийгдэх дотоод болон хөндлөнгийн аудитаар ажиллах аудиторруудын үйл ажиллагааг хянах, ТУЗ болон Хувьцаа эзэмшигчид нэрсийг санал болгох, сонгон шалгаруулах, цалин урамшуулал олгох, ажлаас чөлөөлөх, аудитын хүрээ, давтамжийг тогтоох, тайлантай танилцах, аудитын дүгнэлтэд дурдсан банкны дотоод хяналтын тогтолцооны сул талууд, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг Гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжийн дагуу тохиромжтой цаг хугацаанд хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй.


ХҮНИЙ НӨӨЦ, ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, банканд үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд банкны цалин урамшууллын бодлого, практикт нь чадварлаг ажилтан, менежерийг ажилд авах, улмаар тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулан хөгжүүлэх замаар банкны бизнесийн зорилтдоо хүрэх, тогтвортой бизнесийн хөгжил авчрахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

АУДИТЫН ГАЗАР

Банкны тоон болон чанарын үзүүлэлтүүд дээр үндэслэн одоо байгаа болон цаашид үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн төвшин тогтоох, эрсдэлтэй цэг болон газар дээрх шалгалтын хэрэгцээг тодорхойлж ажиллана. Банкны үйл ажиллагаанд газар дээр нь хийх шалгалтын төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан, үр дүнг ТУЗ-д танилцуулан, шаардлагатай арга хэмжээг авч, зөвлөмжийг өгч ажиллана.

Бүтэц, зохион байгуулалт



Удирдлагын баг |



**Балдандоржийн
АРИУНЖАРГАЛ**

Гүйцэтгэх захирлын үүрэг
гүйцэтгэгч



**Осордэлэгийн
ХҮРЭЛБААТАР**

Дэд захирал



**Бат-Очирын
БЯМБАНОРОВ**

Дэд захирал



**Батсайханы
ОЮУНЦЭЦЭГ**

Бизнес хөгжлийн газрын
захирал



**Мөнхчулууны
САНЧИР**

Хөрөнгө зохицуулалтын
газрын захирал



**Хүрэлбаатарын
АНХСҮРЭН**

Бизнес банкны газрын захирал



**Шаравсамбуугийн
ЭНХТӨР**

Захиргаа, эрх зүйн газрын
захирал




**Энхбатын
АНАНД**

Санхүү удирдлагын газрын
захирал



**Тэгшсайханы
ГАН-ЭРДЭНЭ**

Эрсдэлийн удирдлагын газрын
захирал



**Жаргалсайханы
МӨНХ-ИТГЭЛТ**

Дотоод хяналтын газрын
захирал



**Баянжаргалын
БАТ-ЭРДЭНЭ**

Мэдээлэл технологийн газрын
захирал



Хараат бус аудиторын тайлан



АРИГ БАНК

Албан Тоот **190**

Огноо **2022 о. 03 / 15**

Хуучбарыг: _____

“ХҮЛЭГТХҮННҮ АУДИТ” ХХК-Д

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

“Ариг банк” ХХК (цаашид “Банк” гэх)-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Осордэлэг овогтой Хүрэлбаатар, банкны Санхүү удирдлагын газрын захирал Энхбат овогтой Ананд, бид энэхүү тайлангийн 1-ээс 56 дугаар хуудсанд толилуулсан тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлсэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу бэлтгэсэн бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



О. ХҮРЭЛБААТАР
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭД ЗАХИРАЛ



Э. АНАНД
САНХҮҮ
УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2022 оны 03 дугаар сарын 15

Чингисийн Эргэн Чөлөө
Хан Уул дүүрэг
Улаанбаатар хот 17061
Монгол Улс

Бойгуулалын утас:
7012 2222
И-мэйл: info@arigbank.mn
Вэб: www.arigbank.mn

Ловоох төв:
7013 3060

000002610

Чингисийн Эргэн Чөлөө
Хан Уул дүүрэг
Улаанбаатар хот 17061
Монгол Улс

Бойгуулалын утас:
7012 2222
И-мэйл: info@arigbank.mn
Вэб: www.arigbank.mn

Ловоох төв:
7013 3060

Хараат бус аудиторын тайлан

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ариг банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Ариг банк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Ариг Банк” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх банкны санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “МНБЕЗ-н дүрэм” гэх)-ийн дагуу компаниас хараат бусаар аудитаа хийж гүйцэтгэсэн ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Асуудлыг онцгойлсон зүйл¹

Тайлант онд болон тайлангийн дараа анхаарал татахуйц банкны үйл ажиллагаанд материаллаг нөлөө бүхий дараах үйл явдлууд байна. Үүнд:

- Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-120, А-132 дугаар тушаалуудаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, Банкны тухай хуулийн 17.3 дэх заалт, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг тус тус ханган ажиллаагүй, банкны зохистой засаглал алдагдаж, Хувьцаа эзэмшигчдийн хурал нь бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй гэж үзэн Монгол банкнаас хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг бүрэн сонгох, банкны зохистой засаглалыг бүрдүүлэх хүртэл банкны эрхлэх 3 үйл ажиллагааг түгтээгүйлэн, зарим үйл ажиллагааг хязгаарласан бөгөөд аудитын тайлан гаргах хүртэл уг хязгаарлалт хэвээр байна.
- Монгол банкны Ерөнхийлөгчийн 2017 оны А276 дугаар тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зуун тэрбум төгрөгт хүргэж нэмэгдүүлэхийг банкуудын Хувьцаа эзэмшигчийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосон. Уг асуудлаар зарим банкуудаас ирүүлсэн хүсэлт болон Коронавируст халдварын цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол банкнаас хэрэгжүүлж буй арга хэмжээг үндэслэн Монгол банкны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд тушаалыг хэрэгжүүлэх хугацааг 2022 оны 03 дугаар сарын 31-ний болгон сунгасан. Банкны зүгээс 2022 оны 03 сарын 15-ний байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг зуун тэрбумд хараахан хүргээгүй бөгөөд Монгол банкны Ерөнхийлөгчийн 2017 оны А276 дугаар тушаалыг хэрэгжүүлэхээр тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Эдгээр асуудлын улмаас бид дүгнэлтээ өөрчлөөгүй.

¹ АОУС 706 Хараат бус аудиторын тайлангийн асуудлыг онцгойлсон хэсэг ба бусад зүйлсийн хэсэг

“Хүлэгтхүннү Аудит” ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1001 тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

3



Хараат бус аудиторын тайлан

Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Эгтээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлсэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий эгтээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн, уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах, эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн өрөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Хараат бус аудиторын тайлан

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Баталсан:

И.Гурвангаа
Гүйцэтгэх захирал
Хүлээт Хүнүү Аудит ХХК

2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот



Хараат бус аудиторын тайлан

► "АРИГ БАНК" ХХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2021 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	41,129,985	20,280,174
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	32,376,829	2,781,844
Хөрөнгө оруулалт	5,276,628	3,623,144
Харилцагчид олгосон зээл ба урьдчилгаа (цэвэр дүнгээр)	16,602,346	24,004,468
Бусад санхүүгийн хөрөнгө	159,211	224,424
Бусад санхүүгийн бус хөрөнгө	3,964,545	5,620,494
Борлуулах зориулалттай хөрөнгө	-	588,608
Үндсэн хөрөнгө	2,787,791	2,905,664
Биет бус хөрөнгө	483,752	602,298
Нийт хөрөнгийн дүн	102,781,087	60,631,118
Өр төлбөр		
Харилцах	3,287,172	1,403,876
Хадгаламж	31,109,366	27,956,678
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	30,276,320	4,719,011
Бусад эх үүсвэр	1,914,913	1,906,597
Бусад санхүүгийн өр төлбөр	293,265	324,725
Бусад санхүүгийн бус өр төлбөр	29,177	39,699
Нийт өр төлбөрийн дүн	66,910,214	36,350,586
Өөрийн хөрөнгө		
Хувь нийлүүлсэн хөрөнгө	50,016,595	35,009,500
Дахин үнэлгээний нэмэгдэл	195,893	195,893
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(14,344,656)	(10,927,902)
Бусад өөрийн хөрөнгө	3,041	3,041
Өөрийн хөрөнгийн дүн	35,870,874	24,280,532
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	102,781,087	60,631,118

► Нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Хараат бус аудиторын тайлан

► "АРИГ БАНК" ХХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2021 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
Хүүгийн орлого	6,419,981	7,278,868
Монголбанканд байршуулсан хөрөнгийн	82,379	186,974
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	671,968	1,522
Үнэт цаасны	1,918,108	1,287,607
Зээлийн	3,747,526	5,802,764
Хүүгийн зардал	2,702,015	4,302,515
Харилцахад төлсөн хүү	85	4,947
Хадгаламжид төлсөн хүү	2,576,118	4,007,889
Зээлийн хүүгийн зардал	18,866	181,164
Бусад хүүгийн зардал	106,946	108,515
Хүүгийн цэвэр орлого	3,717,966	2,976,353
Эрсдэлийн сангийн зардал	2,604,917	9,626,700
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого	1,113,049	(6,650,347)
Хүүгийн бус орлого	95,632,371	119,583,929
Арилжааны орлого	607,515	382,670
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	94,599,045	118,768,593
Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	355,902	349,011
Бусад хүүгийн бус орлого	69,909	83,655
Бусад орлого, олз	2,830,233	3,440,025
Хүүгийн бус зардал	103,253,956	125,392,282
Бусад эрсдэлийн сангийн зардал	2,489,992	933,390
Арилжааны зардал	245,361	166,719
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	94,615,416	118,647,296
Хураамж, шимтгэлийн зардал	256,220	207,502
Үйл ажиллагааны бусад зардал	5,646,967	5,437,377
Бусад зардал, гарз	96,020	21,644
Татварын өмнөх ашиг, алдагдал	(3,774,322)	(9,040,319)
Орлогын татварын зардал	(357,569)	(913,957)
Татварын дараах ашиг, алдагдал	(3,416,753)	(8,126,362)
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал		
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	(3,416,753)	(8,126,362)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(3,416,753)	(8,126,362)

► Нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



Хараат бус аудиторын тайлан

► "АРИГ БАНК" ХХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,009,500	195,893	3,041	(2,850,030)	32,358,405
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				48,489	48,489
Залруулсан үлдэгдэл	35,009,500	195,893	3,041	(2,801,541)	32,406,893
Тайлант үеийн ашиг (алдагдал)				(8,126,362)	(8,126,362)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,009,500	195,893	3,041	(10,927,903)	24,280,532
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	35,009,500	195,893	3,041	(10,927,903)	24,280,532
Тайлант үеийн ашиг (алдагдал)				(3,416,753)	(3,416,753)
Өмчид гарсан өөрчлөлт	15,007,095				15,007,095
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,016,595	195,893	3,041	(14,344,656)	35,870,874

► Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

8

Хараат бус аудиторын тайлан

► "АРИГ БАНК" ХХК-ийн 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН


Мянган төгрөгөөр	2021 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	(3,774,322)	(9,040,319)
Орлого, зардлын тохируулга:	14,027,162	10,768,018
Эрсдэлийн сангийн зардал	5,094,909	10,560,090
Элэгдэл, хорогдлын зардал	896,157	875,545
Хуримтлуулсан хүүгийн (орлого)	(6,419,981)	(7,278,868)
Хуримтлуулсан хүүгийн зардал	2,702,015	4,302,515
Хөрөнгө данснаас хассаны гарз (олз)	287	7,004
Бусад олз, гарз	11,753,774	2,301,732
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	10,008,542	(8,754,060)
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн бууралт (өсөлт)	(29,594,985)	8,715,649
Арилжааны үнэт цаасны бууралт (өсөлт)		-
Зээлийн бууралт (өсөлт)	6,901,015	21,226,470
Бусад санхүүгийн хөрөнгийн бууралт (өсөлт)	65,213	58,445
Бусад санхүүгийн бус хөрөнгийн бууралт (өсөлт)	1,655,949	(3,669,339)
Харилцах, хадгаламжийн өсөлт (бууралт)	5,469,659	(33,510,318)
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (бууралт)	25,553,674	(922,933)
Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (бууралт)	(31,460)	(425,011)
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (бууралт)	(10,522)	(227,023)
Бусад тохируулга:	3,194,363	1,386,807
Авсан хүү	6,786,043	8,012,514
Төлсөн хүү	(3,133,727)	(5,949,911)
Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага	(457,953)	(675,796)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	23,455,745	(5,639,554)
Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	217,500	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(830,131)	(87,620)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(118,545)	(3,678)
Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн		-
Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	(1,639,700)	(445,400)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,370,876)	(536,698)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	18,848	
Бусад эх үүсвэрт төлсөн	(18,866)	(375,400)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	(218,668)	(113,436)
Бусад		(23,302)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(218,687)	(512,138)
Валютын ханшийн зөрүү	(16,370)	121,298
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	20,849,811	(6,567,093)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,280,174	26,847,267
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,129,985	20,280,174

► Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.


9

2021.12.31-ний байдлаарх санхүүгийн үзүүлэлтүүд

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа




2021.12.31-ний байдлаарх санхүүгийн үзүүлэлтүүд


НИЙТ ХӨРӨНГӨ (тэрбум төгрөг)




ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ (тэрбум төгрөг)



ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ (тэрбум төгрөг)



ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (тэрбум төгрөг)



НИЙТ ОРЛОГО (тэрбум төгрөг)



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ (тэрбум төгрөг)



2021 онцлох үйл явдлууд

- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 50 тэрбум төгрөгт хүргэлээ.
- Бизнесийн шинэ стратеги, зорилго зорилттой уялдсан бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг бүрэн хэрэгжүүллээ.
- Цахим бүтээгдэхүүний шинэ боломжуудыг нэмснээр харилцагч зайнаас бүх төрлийн татвар төлөх, хэрэглээний төлбөр төлөх, зээлийн хүсэлтээ онлайнаар илгээж судлуулах боломжтой боллоо.




- Хэрэглээний худалдан авалтын зээл, шинэ автомашины лизингийн зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж, зээлийн бүтээгдэхүүний нөхцлүүдийг сайжрууллаа.
- Төрөөс хэрэгжүүлж буй зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд зээлийн хүүг үе шаттайгаар бууруулж, зээлийн хүүгийн урамшуулалт аяныг зохион байгууллаа.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд Ариг банкны хамт олон нэгдэж, “СХД, Бумбатын булаг” орчимд мод тарилаа.
- Эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөний гол арга хэмжээнүүдийн нэг болох Ажлын байрыг дэмжих 3%-ийн зээлийг олголоо.



■ Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг |

2021 онд банкны “Харилцагчийн Үйлчилгээний Төв”-д буюу Лавлах төвийн 70133060 (24/7) утас болон бусад 17-н сувгаар давхардсан тоогоор 102,466 мянган харилцагчид хандан үйлчилгээ, мэдээлэл авсан байна. Ковид-19 цар тахал дэлхий нийтийг хамарч хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор банкны нийт хандалт 23%-иар нэмэгдсэн байна. Лавлах төв нь хүний нөөцийн хүчин чадлыг ашиглан 24/7 горимоор үйлчилгээг тасралтгүй явуулан нийт хандсан дуудлагын 87.5%-ийг амжилттай хүлээн авч, харилцагчдаа хүлээлгэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Түүнчлэн тайлант хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Харилцагчийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах замаар харилцагчийн эрх ашгийг хамгаалан, шийдвэрлүүлэх шаардлагатай саналуудыг холбогдох газар, хэлтэст дамжуулан ажиллалаа.
- Харилцагчдад шууд үйлчилгээ үзүүлэх суваг буюу Веб чатыг 3-р улиралд нэвтрүүлснээр бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг түргэн шуурхай авах боломжийг нээн үйлчилгээ авах сувгийг нэгээр нэмэгдүүлсэн.
- ISO 10002 стандартад нийцүүлэн харилцагчийн өмнө хүлээсэн үүргийн дагуу харилцагчид үнэн зөв, мэдээллийг түргэн шуурхай дамжуулан, нууцлалыг ханган ажилласан бөгөөд өмнөх жилтэй харьцуулахад гомдол 45%-иар буурч харилцагчдын сэтгэл ханамжийн үнэлгээ 85%-тай байна.



Технологийн инноваци



Бид хэрэглэгчдийнхээ тав тухтай, бүтээмж өндөртэй, аюулгүй байдлыг тэргүүн эгнээнд тавин ажилладаг билээ.

Бид хэрэглэгчдийнхээ тав тухтай, бүтээмж өндөртэй, аюулгүй байдлыг тэргүүн эгнээнд тавин ажилладаг билээ. Энэхүү зорилгын хүрээнд бид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ олон сувгаар, цаг хэмнэн хүргэх үүднээс дижитал технологийг ашиглан SWIPE карт уншигч, PocketBank гар утасны аппликейшн, интернэт банк, хурууны судасны байрлалаар таних шинэ технологи IDual, автомат бэлэн мөнгөний машин TCR зэргийг нэвтрүүлээд багагүй хугацаа өнгөрсөн байна.

Тайлант онд орчин үеийн технологийн чиг хандлагыг шингээсэн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа үзүүлэх, мэдээлэл технологийн үйл ажиллагааны тасралтгүй найдвартай байдлыг хангах үүднээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Банкны дата төвийн нөөц төвүүдийг байгууллаа.
- Цахимаар данс нээх үйлчилгээг нэвтрүүлээ.
- Цахим суваг ашиглан төлбөр төлөх боломжуудыг нэмлээ.
- Зээлийн төлбөр хойшлуулах хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэлээ.
- Өгөгдлийн сан болон системүүдийг тасралтгүй сайжруулан холбогдох туршилтуудыг цаг тухай бүр хийж гүйцэтгэлээ.

Цаашид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн банкны бүхий л бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас авах боломжийг бий болгож, интернет банк, покет банкны үйлчилгээг улам сайжруулан, харилцагчийн төлбөр тооцоог түргэн шуурхай, нууцлалын өндөр түвшинд тасралтгүй найдвартай гүйцэтгэх зорилго тавин ажиллаж байна.



■ Хүний нөөцийн үйл ажиллагаа

Ариг банк нь тайлан хугацаанд 150 гаран ажилтантай ажилласнаас 35%-ийг эрэгтэй, 65%-ийг эмэгтэй ажилтнууд эзэлж, нийт ажилтнуудын дундаж нас 33 байна. Банкны үйл ажиллагааг тасралтгүй хангах үүднээс шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд 55 ажилтныг сонгон шалгаруулан ажлын байраар хангахаас гадна ажилтнуудынхаа карьер хөгжлийн дагуу 10 гаруй ажилтныг албан тушаал дэвшүүлэн ажлуулсаныг дурьдахад таатай байна.


Цар тахлаас хамааран төлөвлөсөн сургалт хөгжлийн үйл ажиллагаа бүрэн хийгдээгүй хэдий ч боломжит сургалтуудыг цахимаар зохион байгуулан дотоодын болон гадны 30 орчим удаагийн сургалтанд давхардсан тоогоор 260 орчим ажилтнуудыг хамруулаа. Мөн тайлант хугацаанд хамт олноо ажил үйлсээрээ манлайлан ажилласан 9 ажилтныг

Монголбанк болон МБХ-ны шагналаар шагнаж урамшуулахын сацуу байгууллагын ахмад настнууддаа Сар шинийн баяраар уламжлал ёсоор хүндэтгэл үзүүллээ.

Хэдийгээр 2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотой бэрхшээлүүд үүссэн ч ажилтнууддаа зайнаас болон богиносгосон цагаар ажиллах, мөн уян хатан цагийн зохион байгуулалт хийх зэргээр хөдөлмөр зохион байгуулалтыг оновчтой, шуурхай хийж ажиллалаа. Түүнчлэн бүх ажилтнуудыг түргэвчилсэн шинжилгээ, PCR шинжилгээ болон вакцинд хамруулах ажлуудыг зохион байгуулах, өвдсөн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгох, ажилтнуудын цалин хөлсийг сул зогсолт болон хөл хорионы үед бууруулахгүй байх чиглэлийг баримтлан ажилласан юм.

ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Нийт ажилтан	152	Дотоод цахим сургалт	7
Эмэгтэй	65%	Гадны байгууллагын цахим сургалт	20
Эрэгтэй	35%	Сургалтанд хамрагдсан ажилтан	258
Дундаж нас	32.5	Шагнал урамшуулал	9
Ажилласан жилийн дундаж	4.8 жил	Банкинд тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үеийн осол гэмтэл	0



Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ



Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлэн орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурлан тайлант онд дараах шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүллээ.

ЦАХИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ШИНЭ БОЛОМЖУУД НЭМЭГДЛЭЭ.

- Юнител, юнивишн, гэр интернетийн төлбөр төлөх - Харилцагч интернет банк ашиглан гэр интернет, юнител, юнивишний төлбөр төлөх нэгж худалдан авах боломжтой боллоо.
- Татвар төлөх – Татварын нэхэмжлэлийн дугаарыг үндэслэн харилцагч бүх төрлийн татвараа хүссэн үедээ төлөх боломж бүрдлээ.
- Харилцах, хадгаламжийн данс нээх, хугацаа сунгах - Покет банк үйлчилгээг ашиглан харилцах хадгаламжийн данс нээх, хадгаламжийн хугацаа сунгах боломжтой боллоо.



- Зээлийн хүсэлтийг онлайнаар илгээх – Харилцагч цаг хугацаа хэмнэн бүх төрлийн зээлийн хүсэлтээ /loan.arigbank.mn/ банкинд онлайнаар өгч, зээлээ судлуулан шийдүүлэх боломжийг олголоо.

ХЭРЭГЛЭЭНИЙ ХУДАЛДАН АВАЛТЫН ЗЭЭЛИЙГ НЭВТРҮҮЛЛЭЭ.

Харилцагчдадаа зориулан Ариг банкны хамтран ажиллах гэрээт байгууллагаас гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилга, компьютер зэргийг худалдан авах



боломжтой таатай нөхцөл бүхий хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ.

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ 3%-ИЙН ЗЭЭЛИЙГ ОЛГОЛОО.

Коронавирусийн халдварт цар тахлын

эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах, бизнесийн үйл ажиллагаа, зах зээлийн идэвхжилийг сэргээх зорилтын хүрээнд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г Монгол Улсын Засгийн газраас боловсруулан, гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр болсон билээ.



Эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөөний гол арга хэмжээнүүдийн нэг болох жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ажлын байрыг дэмжих, хадгалах зорилготой хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгох 2 их наяд төгрөгийн санхүүжилтийн хөтөлбөрийг Ариг банк салбар нэгжээрээ дамжуулан амжилттай хэрэгжүүллээ.

ШИНЭ АВТОМАШИНЫ ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТРҮҮЛЛЭЭ.

Шинэ автомашин борлуулдаг аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж шинэ автомашины лизингийн зээлийн үйлчилгээг харилцагчдадаа зориулан шинээр нэвтрүүллээ. Энэхүү шинэ



бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээр харилцагч 10%-20%-ийн урьдчилгаа төлбөр төлж, сарын 1,2%-1,35%-ийн хүүтэй зээлийг 48-96 сарын хугацаатайгаар түргэн шуурхай шийдүүлэн авах боломжтой болсон юм.

ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА.

Төрөөс хэрэгжүүлж буй зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд Монголбанкнаас бодлогын хүүг бууруулсантай холбогдуулан жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан зээлийн хүүг үе шаттайгаар 20-30 хувиар бууруулж, зээлийн хүүнд өөрчлөлт оруулан ажиллалаа. Уг ажлын хүрээнд бизнесийн болон хэрэглээний зээлийн хүүг сарын 1.4%-иас 1.2% болгон бууруулан зээлийн хүүгийн урамшуулалт аяныг зохион байгуулж бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллалаа.



■ Эрсдэлийн удирдлага |

Эрсдэлийн удирдлагын бүтэц нь 4 түвшинд хуваагдана.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд дараах эрсдэлээс сэргийлж ажиллана. Үүнд:

- Ашиглан,
- Залилан,
- Ажлын байрны аюулгүй байдлын эрсдэл,
- Харилцагчийн эрсдэл,
- Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл,
- Мэдээлэл технологийн системийн эрсдэл,
- Дотоод үйл явцын эрсдэл,
- Гадаад хүчин зүйлийн эрсдэл,
- Хуулийн болон гадны зохицуулалтад үл нийцэх эрсдэл,
- Хариуцлагын эрсдэл,
- Хөрөнгийн эрсдэл,
- Боловсон хүчний эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь банкны үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг тодорхойлох, эрсдэлийг үүсгэж буй хүчин зүйлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга замын талаар шийдвэрүүдийг гаргаж гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж ажилладаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлийн үндсэн гурван чиглэлд тулгуурлан эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэгдэж байна.

1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Эрсдэлийн Удирдлагын Хороо / ТУЗ-н ЭУХ/: Эрсдэлийн удирдлагын баримтлах стратеги, бодлого болон банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах.

2 Банкны Эрсдэлийн Хороо /ЭХ/ нь банкны эрсдэлийн бодлого, үйл ажиллагаа нь банкны үндсэн үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, түүний хэрэгжилтийг ТУЗ-ийн ЭУХ-д тайлагнах банкны гол эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авах, эрсдэлийн удирдлагатай холбоотой журам зааврыг батлах, эрсдэлийн соёлыг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг хамаарна.

3 Эрсдэл хариуцсан нэгж болох Эрсдэлийн удирдлагын газар, Дотоод хяналтын газар нь эрсдэлийн бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, мөн банкны үйл ажиллагааг дэмжих болон удирдах нэгжүүд, бизнес нэгжүүдийн эрсдэлийн удирдлагад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагад оролцогчдыг холбох, эрсдэлийн нэгдсэн мэдээллээр хангах, банкны эрсдэлийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулах ажиллагааг хариуцна.

4 Салбар, тооцооны төв нь өөрсдийн хариуцан ажиллаж буй үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийг удирдаж ажиллана.

Өнгөрөгч онд банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хяналтын тогтолцооны оновчтой байдлыг үнэлэн, зөвлөмж боловсруулан холбогдох газар нэгжид хүргүүлэх замаар үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан.

2021 онд гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлж, банкны мэдээллийн болон бүртгэлийн системд хандах хэрэглэгчийн эрхийн зохицуулалтыг шинэчлэн боловсруулж, хэрэглэгчийн зүй бус хандалт, хэрэглээнээс үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж хүлээн зөвшөөрөх хамгийн бага түвшинд барьж ажиллалаа. Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд бодлого журмыг шинэчлэн баталж мэдээллийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2021 онд Монголбанкнаас шинэчлэн баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-тай холбогдуулан дотоод дүрэм, журамд шинэчлэлт хийж, үлдэгдэлтэй зээлийн ангиллыг өөрчилж, эрсдэлийн сан байгуулан Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажилласан. 2021 онд Ариг Банк нь зээлийн эрсдэлийн бодлогоо нарийвчлан тодорхойлж, эдийн засгийн нөхцөл байдал, банкны богино болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй уялдуулан, зээлийн эрсдэлийн хязгааруудыг шинэчлэн өөрчилж, зээлийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан оновчтой хэрэгжүүлсэн. Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр зээлийн

багцын чанар муудах мөн эдийн засгийн салбар, валют, зээлийн нэг бүтээгдэхүүнд эсвэл холбоотой бүлэг этгээдэд зээлийн хэт төвлөрөл бий болгохоос урьдчилан сэргийлэх, түүнчлэн банк эрх бүхий байгууллага болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд бид зээлийн багцын чанарт үнэлгээ хийх, хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тодорхойлох, төвлөрлийн эрсдэлийг үнэлэх, хязгаарлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр зээлийн багцын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна. Ариг Банк нь үр ашигтай эрсдэлийн удирдлагын гол үзүүлэлт болох эрсдэлийн хязгаарлалтуудыг банкны хэмжээнд, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг тооцоолон зохистой хэмжээнд боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилладаг. Ариг Банкны үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр зээлийг тухайн өдөрт нь бус цаг, минутын дотор шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага нэмэгдсээр байна. Мөн зээлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх үүднээс банкны салбар, тооцооны төвүүд, Зээлийн Хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөл зэрэг зээл шийдвэрлэх түвшин болгонд зээлийн дээд хэмжээг тодорхойлж, зээлдэгчийн зээлжих чадварыг үнэлэн ажиллаж байна.



Салбар нэгжийн мэдээлэл

Банкны салбар нэгжүүд тав тух, аюулгүй байдлыг эрхэм болгон харилцагчдадаа үйлчилж байна. Бид салбар нэгжүүд болон оффисуудаа дулаан, тайван, зочломтгой уур амьсгалтай байлгах зорилгоор хамгийн тайван өнгө болох нил ягаан өнгөөр голлон тохижуулсан билээ. Манай салбар нэгжүүдээр өөрийн бизнес, ажил хэргээ тэлэн, санхүүгийн шийдлээ олохоор зорин ирсэн үйлчлүүлэгч бүрт ажиллагсад маань тусгайлан анхаарч үйлчлэхээс гадна цай, кофены булангаас хүссэнээрээ үйлчлүүлэх боломжтой байдаг билээ.

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Ариг Банк нь нийт 50,000 харилцагчиддаа Улаанбаатар болон Дархан хотуудад байрших нийт 11 салбар нэгжээр дамжуулан үйлчилсэн байна. Цаашид бид салбар нэгжүүдийнхээ тохижилтыг олон улсын банкуудын дизайн, тохижилт бүхий засварын ажлыг хийж, салбарын гадаад, дотоод орчныг сайжруулан, өнгө төрхийг шинэчилхээр ажиллаж байна.

11

Салбар нэгжүүд

8

Улаанбаатар хот

3


Дархан хот

50,000

Харилцагчид

3 үгт хаяг

- Хан-Уул ТТ //явах.найдлага.малтмал
- Сонгинохайрхан ТТ //тэмүүлэл.онцлог.нүхлэх
- Баянзүрх ТТ //аялдаг.дайчлах.жишээлэх
- Хан-Уул Юнайтэд ТТ //давхцал.үйлдэх.найрамдал
- Хороолол Салбар //ариусах.өгүүлбэр.айзам
- 40Мянгат ТТ //далан.сүлжээ.улиас
- М20 ТТ //уянгалаг.жишээлэх.тансаг
- Бөмбөгөр ТТ //сондгой.түшиг.аргачлал
- Престиж ТТ //тэнхимд.арслан.цацуу
- Дархан Салбар //баясав.зууван.хэрэглээг
- Дархан Олон улс ТТ //алаглах.үдэлт.цонх
- Дархан Зах ТТ //нуур.тогоо.тогос



■ Бидний түншүүд |





Thank You.

Хаяг

Чингисийн өргөн чөлөө
Хан-Уул дүүрэг
Улаанбаатар хот 17061
Монгол Улс

Холбоо барих

Утас: 7013 3060
Цахим шуудан: info@arigbank.mn

www.arigbank.mn